



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2024/228-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: [urtaa6969@gmail.com](mailto:urtaa6969@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт .....	3-4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	14
3.5.3 Нэмэлт төсөв .....	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, материал, ажил үйлчилгээ худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

АЛТАНБУЛАГ СУМЫН  
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ У.ТЭРГҮҮНБАЯР ТАНАА

2024. 02. 23 № СА-2024/228-НА.СА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус цэцэрлэг нь төсвийн хөрөнгөөр 1,551.0 мянган төгрөгийн гадна, дотор 6 ширхэг камер худалдан авсан байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

018020253

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 80.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>45,968,404.40</b>	<b>79,690,536.71</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>26,210,493.00</b>	<b>61,166,810.31</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,210,493.00	61,166,810.31
31210	Төгрөг	26,210,493.00	61,166,810.31
31211	Төрийн сангийн харилцах	26,210,493.00	61,166,810.31
33	<b>АВЛАГА</b>	<b>513,395.00</b>	<b>0.00</b>
33500	Бусад авлага	513,395.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	513,395.00	0.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>19,244,516.40</b>	<b>18,523,726.40</b>
35400	Хангамжийн материал	19,244,516.40	18,523,726.40
35410	Бичиг хэргийн материал	567,100.00	56,500.00
35420	Аж ахуйн материал	15,802,532.40	16,660,954.40
35440	Түлш, шатах тослох материал	1,119,440.00	1,256,000.00
35460	Хүнсний материал	1,755,444.00	550,272.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>695,781,257.27</b>	<b>675,774,855.13</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>695,781,257.27</b>	<b>675,774,855.13</b>
39200	Биет хөрөнгө	695,442,715.71	675,748,813.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	697,041,022.00	697,041,022.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(27,107,150.84)	(38,724,501.20)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	27,251,828.30	28,802,828.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,995,600.59)	(21,817,724.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,124,282.50	7,124,282.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,538,332.28)	(2,343,760.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,000,000.00	10,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,333,333.38)	(4,333,333.42)
39300	Биет бус хөрөнгө	338,541.56	26,041.52
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(911,458.44)	(1,223,958.48)
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>741,749,661.67</b>	<b>755,465,391.84</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>741,749,661.67</b>	<b>755,465,391.84</b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>741,749,661.67</b>	<b>755,465,391.84</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>741,749,661.67</b>	<b>755,465,391.84</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	0.00	741,749,661.67
51220	Тайлант үеийн үр дүн	741,749,661.67	13,715,730.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>741,749,661.67</b>	<b>755,465,391.84</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>970,861,746.15</b>	<b>302,639,930.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>734,148,774.15</b>	<b>513,395.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>734,148,774.15</b>	<b>513,395.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>513,395.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	513,395.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	717,236,492.75	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,912,281.40	0.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>236,712,972.00</b>	<b>302,126,535.21</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>201,781,300.00</b>	<b>283,586,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,781,300.00	283,586,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>34,931,672.00</b>	<b>18,539,935.21</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,931,672.00	18,539,935.21
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>229,112,084.48</b>	<b>288,924,200.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>229,112,084.48</b>	<b>288,924,200.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>229,112,084.48</b>	<b>288,924,200.04</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>147,515,813.00</b>	<b>192,958,955.00</b>
210101	Үндсэн цалин	110,287,164.00	142,202,180.00
210102	Нэмэгдэл	28,511,610.00	41,315,209.00
210104	Урамшуулал	8,717,039.00	9,441,566.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,839,847.00</b>	<b>25,718,697.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,597,666.96	17,389,123.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,560,891.83	2,030,574.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,248,674.28	1,838,951.00

210204	Ажилгүйдлийн даатгал	310,943.27	398,901.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,121,670.66	4,061,148.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,036,004.00</b>	<b>14,934,375.21</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,539,804.00	4,395,737.91
210302	Түлш, халаалт	6,696,200.00	8,918,637.30
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,620,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>18,534,463.00</b>	<b>22,095,047.00</b>
210502	Хоол, хүнс	18,534,463.00	22,095,047.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,196,000.00</b>	<b>3,091,000.00</b>
210604	Урсгал засвар	1,196,000.00	3,091,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>260,000.00</b>	<b>480,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	260,000.00	480,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>28,729,957.48</b>	<b>29,646,125.14</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,870,022.00	7,304,968.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,404,700.00	783,755.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,455,235.48	21,557,402.14
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>741,749,661.67</b>	<b>13,715,730.17</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>741,749,661.67</b>	<b>13,715,730.17</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>236,712,972.00</b>	<b>302,639,930.21</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>513,395.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>513,395.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>513,395.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	513,395.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>236,712,972.00</b>	<b>302,126,535.21</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>201,781,300.00</b>	<b>283,586,600.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	201,781,300.00	283,586,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>34,931,672.00</b>	<b>18,539,935.21</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	34,931,672.00	18,539,935.21

	төсөвт байгууллага/		
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>210,502,479.00</b>	<b>266,132,612.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>210,502,479.00</b>	<b>266,132,612.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>210,502,479.00</b>	<b>266,132,612.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>148,029,208.00</b>	<b>192,958,955.00</b>
210101	Үндсэн цалин	110,287,164.00	142,202,180.00
210102	Нэмэгдэл	29,025,005.00	41,315,209.00
210104	Урамшуулал	8,717,039.00	9,441,566.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,839,847.00</b>	<b>25,718,697.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,597,666.96	17,389,123.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,560,891.83	2,030,574.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,248,674.28	1,838,951.00
210204	Ажилгүйдлийн даатгал	310,943.27	398,901.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,121,670.66	4,061,148.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,002,804.00</b>	<b>15,070,935.21</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,539,804.00	3,373,526.00
210302	Түлш, халаалт	6,663,000.00	10,617,409.21
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	1,080,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>19,994,820.00</b>	<b>20,889,875.00</b>
210502	Хоол, хүнс	19,994,820.00	20,889,875.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,196,100.00</b>	<b>3,469,000.00</b>
210604	Урсгал засвар	2,196,100.00	3,469,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>235,000.00</b>	<b>497,700.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	235,000.00	497,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,204,700.00</b>	<b>7,527,450.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,704,700.00	5,960,695.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,566,755.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>26,210,493.00</b>	<b>36,507,317.31</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>1,551,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>1,551,000.00</b>

2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1,551,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	1,551,000.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	0.00	<b>(1,551,000.00)</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	0.00	<b>0.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>26,210,493.00</b>	<b>34,956,317.31</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	26,210,493.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,210,493.00	61,166,810.31

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	741,749,661.67	741,749,661.67
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	741,749,661.67	741,749,661.67
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	741,749,661.67	741,749,661.67
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	741,749,661.67	741,749,661.67
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,715,730.17	13,715,730.17
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	755,465,391.84	755,465,391.84

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>328,850,428.21</b>	<b>267,683,612.90</b>	<b>61,166,815.31</b>	81.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,850,428.21	267,683,612.90	61,166,822.31	81.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,310,500.00	267,683,612.90	61,166,822.31	86.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	245,586,300.00	192,958,955.00	52,627,345.00	78.6

210101	Үндсэн цалин	160,719,900.00	142,202,180.00	18,517,720.00	88.5
210102	Нэмэгдэл	76,444,400.00	41,315,209.00	35,129,191.00	54.0
210104	Урамшуулал	8,422,000.00	9,441,566.00	-1,019,566.00	112.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,144,500.00</b>	<b>25,718,697.69</b>	<b>5,425,802.31</b>	82.6
210201	Тэтгэврийн даатгал	21,177,700.00	17,389,123.69	3,788,576.31	82.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,491,700.00	2,030,574.00	461,126.00	81.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,993,500.00	1,838,951.00	154,549.00	92.2
210204	Ажилгүйдлийн даатгал	498,300.00	398,901.00	99,399.00	80.1
210205	Эрүүл мэндийн даатгал	4,983,300.00	4,061,148.00	922,152.00	81.5
	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,070,935.21</b>	<b>15,070,935.21</b>	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	3,373,526.00	3,373,526.00	-	100.0
210302	Түлш, халаалт	10,617,409.21	10,617,409.21	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,080,000.00	1,080,000.00	-	100.0
	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,469,000.00</b>	<b>3,469,000.00</b>	--	100.0
210604	Урсгал зардал	3,469,000.00	3,469,000.00		100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>23,533,493.00</b>	<b>20,889,875.00</b>	<b>2,643,625.00</b>	88.8
210502	Хоол, хүнс	23,533,493.00	20,889,875.00	2,643,625.00	88.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>522,600.00</b>	<b>497,700.00</b>	<b>24,900.00</b>	95.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	522,600.00	497,700.00	24,900.00	95.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,523,600.00</b>	<b>9,078,450.00</b>	<b>445,150.00</b>	95.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,955,700.00	7,511,695.00	444,005.00	94.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,567,900.00	1,566,755.00	1,145.00	99.9
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>328,850,428.21</b>	<b>302,639,935.21</b>	<b>26,210,505.00</b>	92.0
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>283,586,600.00</b>	<b>283,586,600.00</b>	-	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	283,586,600.00	283,586,600.00	-	100.0
	Орон нутгийн төсвөөс	18,539,935.21	18,539,935.21	-	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>26,723,893.00</b>	<b>513,400.00</b>	<b>26,210,493.00</b>	-

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	513,400.00	513,400.00	0.00	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	26,210,493.00	-	26,210,493.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	--	26,210,493.00	-	--
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		61,166,810.31	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд ба багшийн хөгжлийг хамтад нь чөлөөт, бүтээлч идэвхтэй үйл ажиллагааны орчинд хүүхэд тоглонгоо хөгжинө” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэн ажиллана.
- Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлчилгээний чанарыг эрхэмлэн, хэрэгцээнд суурилсан багшийн хөгжлийг дэмжиж ажиллана.
- Хүүхэд бүрийн авьяас, чадварыг нээн хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллана.
- Цэцэрлэгийн орчинд хүүхдийг болзошгүй эрсдэлээс хамгаалж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэн ажиллана.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.

*ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”,  
“2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл  
ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах”  
чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,715.7 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,210.50	61,166.80	34,956.30
Авлага	513.40	-	(513.40)
Бараа материал	19,244.50	18,523.70	(720.80)
Үндсэн хөрөнгө	695,781.30	675,774.90	(20,006.40)
Нийт хөрөнгө	<b>741,749.70</b>	<b>755,465.40</b>	<b>13,715.70</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	741,749.70	755,465.40	13,715.70
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>741,749.70</b>	<b>755,465.40</b>	<b>13,715.70</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 61,166.8 мянган төгрөг болж 34,956.3 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9<sup>1</sup>-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансны үлдэгдэл 513.4 мянган төгрөгөөр буурсан нь аудитын актын төлбөр илүү шилжүүлсэнийг барагдуулснаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 18,523.7 мянган төгрөг болж 720.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 37,511.5 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 38,232.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,

<sup>1</sup> Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 675,774.9 мянган төгрөг болж 20,006.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,551.0 мянган төгрөгийн гадна, дотор 6 ширхэг камер худалдан авсан, тайлант онд нийт 21,557.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 256,753.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 21,959.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **278,713.4** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин НДШ-н зардлыг 14,137.4 мянган төгрөгөөр, хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардлыг 1,590.4 нэмэгдүүлж нийт төсвийг **294,441.2** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн зохицуулалтаар цалин хөлсийг 34,832.6 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 1,727.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,269.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 3,419.8 мянган төгрөгөөр бууруулж, нийт **328,850.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 309,797.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 18,540.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 513.3 мянган төгрөг зэрэг нийт **328,850.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **267,683.6** мянган төгрөг буюу 81.4 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг 58,053.1 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 2,643.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 445.2 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг 24.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр /*

Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	784.00	603.00	(181.00)	77.3
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	23,533.50	20,889.90	(2,643.60)	88.8
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,590.40	1,590.40	-	100.0
		4	81823-Боловсролын байгууллагын багш	784.00	521.00	(263.00)	66.5
		5	81834-Боловсролын стандарт сургалт	166,536.50	135,939.00	(30,597.50)	81.6
		6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	116,568.70	89,087.00	(27,481.70)	76.4
		7	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	513.40	513.40	-	100.0
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	15,070.90	15,070.90	-	100.0
		9	80112-Нийтлэг үйлчилгээ	3,469.00	3,469.00	-	100.0
<b>Нийт</b>				<b>328,850.40</b>	<b>267,683.60</b>	<b>(61,166.80)</b>	<b>81.4</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	22,924.0	20,889.9	НТШ
	<b>Нийт дүн</b>	<b>22,924.0</b>	<b>20,889.9</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Бумбат арвижих” ХХК-тай 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд хоол хүнс, цэвэрлэгээний материалыг Бумбат арвижих ХХК, нүүрсийг Баялаг буянт тулга ХХК, хүнс ахуй, бичиг хэргийн материалыг Цахим ертөнц ХХК, сургалтын хэрэглэгдэхүүнийг Сэцэн төгөлдөр буянт ХХК-тай тус тус гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн

үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 229,112.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,291.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Алтанбулаг сумын 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг 1 удаа хугацаа хоцроож, 11 удаа дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага үүсгэсэн, бараа материалын худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулалгүй зөрчлийг давтан гаргасан тул 2,676.4 мянган төгрөгийн албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	2,676.4	2	2,676.4	100.0
Нийт дүн	2	2,676.4	2	2,676.4	100.0

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **701.2** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 570.0 мянган төгрөгийн хоолны зардлыг цалингийн зардалд ангилал буруу бүртгэсэн байна.
- Хүүхдийн хоолны зарцуулалтын тайланг 131.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хоолны зардлыг цалингийн зардалд ангилал буруу бүртгэсэн.	1	570.0			1	570.0	1	570.0				
Хүүхдийн хоолны зарцуулалтын тайланг дутуу тайлагнасан.	1	131.2	1	131.2			1	131.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>701.2</b>	<b>1</b>	<b>131.2</b>	<b>1</b>	<b>570.0</b>	<b>2</b>	<b>701.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шидэн дансанд 1 мэдээллийг хугацаа хоцроож, 11 мэдээллийг	1	-							1	-		

дутуу мэдээлсэн.								
<b>Дүн</b>	<b>1</b>	-	-	-	-	-	<b>1</b>	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	-	-	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	-	-	-	-	-	<b>1</b>	-